

**УГСААТНЫ БҮЛЭГТЭЙ АЖИЛЛАХ НИЙГМИЙН АЖЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ /ХОРИХ
БАЙГУУЛЛАГЫН НИЙГМИЙН АЖЛЫН ЖИШЭЭН ДЭЭР/**

**FEATURES AND ISSUES OF SOCIAL WORK SERVICES WORKING WITH
ETHNIC GROUPS /ON THE EXAMPLE OF SOCIAL WORK IN A PRISON/**

Г.Батжаргал

Дотоод хэргийн их сургууль Сургалт, судалгааны 403 дугаар анги Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн ахлах багш, хошууч

Хураангуй: Глобалчлагдаж байгаа дэлхий ертөнцөд угсаатны бүлэгтэй ажиллах нийгмийн ажил туйлын чухал болоод байна. Аливаа нийгэмд амьдарч байгаа хүн нийгмийн гишүүн болохын хувьд нас, хүйс, сошиал статусаасаа хамаараад үнэт зүйл, зан үйл, амьдрах хэв маяг, дүр нь ялгаатай байдгийн адил тухайн хүн ямар "угсаатан"-ы бүлэгт хамаарч байгаагаас шалтгаалж мөн л ялгааг үүсгэж байгаа нь угсаатны бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээний арга зүйг боловсруулах үндсэн шаардлага болж байна.

Ялгаатай байдал эсвэл олон талт байдал гэж орчуулах энэ ойлголт нь хүн бүр тодорхой нийтлэг шинжээрээ өөр бусдаасаа ялгагдана. Орчин үеийн нийгэмд хүний ийм тал шинж бүр нь нийгмийн харилцаанд нөлөө үзүүлдэг. Жишээ нь АНУ-д "африк" гаралтай америкчууд арьсны өнгөөрөө, Германы "туркууд" хөдөлмөрийн гэрээгээр ирээд үлдсэн цагаачид, БНХАУ-ын "өвөрмонголчууд" нь "үндэсний цөөнх", Солонгост албан ёсоор ажил эрхэлдэг "Монголчууд" нь "гадаад ажилчин" гэдгээрээ, Европт үйл олноороо очоод байгаа сирийн "дүрвэгсэд"-ийн асуудал нь тэдний "олон талт байдал" нь холбоотой, мөн нийгэмд эзлэх байр суурь нь ижилгүй. Үүнтэй холбоотой "гадаад ажилчин", "үндэсний цөөнх", "цагаач", "дүрвэгсэд", "угсаатны бүлэг" гэсэн ялгаатай ойлголтууд гарч ирдэг. 1990 оноос хойш дэлхий ертөнцөд нэг талаас угсаатантай холбоотой үндсэрхэг үзэл, соёл, шашны сэргэлт хүчтэй болж нөгөө талаасаа глобалчлал хөгжилтэй холбоотой улс орнуудад олон янзын угсаатны бүлэг зэрэгцэн амьдрах болов. Иймд угсаатны нийгмийн ажлыг нийгмийн ажлын салбар бүрд судалж, хөгжүүлэх нь чухал байна.

Түлхүүр үг: Угсаатны бүлэг, үндэсний цөөнх, нийгмийн ажил,

Удиртгал

"Нийгмийн ажлын судалгаа" хэмээх нийгмийн ажилтнуудын мэргэжлийн сэтгүүлд Бонгки Вуу, Виктор Фугиерео, Роберт Росалес зэрэг зохиогчдын "Угсаатан ба арьсны асуудал нийгмийн ажилд байдаг уу?" гэсэн мэргэжлийн сэтгүүлд нийтлэгдсэн 634 өгүүлэлд шинжилгээ хийж үзэхэд ихэнх нь угсаатан, арьсны ялгаатай бүлгийг судалгааны ажлын үндсэн бүлэг бус харин хяналтын

хавсарга бүлгээр авч үзсэн, маш цөөхөн өгүүлэлд угсаатан, арьсны бүлгийн асуудлыг тусгайлан нухацтай судалсан өгүүлэл нийтлэгдсэн болохыг илрүүлжээ. Үүн дээр үндэслэн зохиогчид дэлхий даяар ч гэсэн нийгмийн ажлын боловсрол хөгжилд "угсаатан"-ы асуудлыг тусгах, анхаарлын төвд оруулах хандлага хүчтэй байна.¹

Монгол орон нь (homogene) буюу нэг угсаатан давамгайлсан хүн ам зүйн бүтэцтэй орон боловч “үндэсний цөөнх” казах, тува иргэдийн нөхцөл байдлыг бодитой танин мэдэж тэдгээр бүлгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх шаардлагатай юм.

Тухайлбал: 1. Монголын хамгийн олон үндэсний цөөнх, угсаатны дэд бүлэг оршин суудаг Ховд аймагт ажиллах нийгмийн ажилтан үйлчилгээ үзүүлэхдээ тухайн үйлчлүүлэгчийн "олон талт байдал", "хэлний ба соёлын өвөрмөц байдал"-ыг харгалзаж тохируулсан үйлчилгээ үзүүлэх шаардлагатай болно. Угсаатны бүлгүүд нь Монголд гарал үүсэл, түүх соёл, шашин шүтлэг, амьдрах хэв маяг, хэл өөр учраас олон улсын ангиллаар "үндэсний цөөнх" гэсэн бүлэгт казах, тува иргэд орно, тэдний "угсаатны бүлэг"-ийн хувьд нийгэмд тулгамдаж байгаа асуудал, хэрэгцээ нь ихээхэн өөр байна. Тиймээс нийгмийн ажилтнууд казах, тува иргэдэд нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэхдээ тэдний ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандаж, тэдний хэрэгцээ, "ижилсэл", тулгамдсан асуудалд тусгайлан анхаарах шаардлагатай болж байна.

2. Өнөөдөр гадаадад амьдардаг Монгол гаралтай хүүхдүүд эргэж Монголд ирж суурьших нь ихэслээ. Эдгээр Монголчуудын хүүхдүүд Монгол хэл соёлыг муу эзэмшсэн бөгөөд нутагтаа эргэж ирээд амьдрахад тодорхой хэмжээний бэрхшээл учирна. Тиймээс сургууль, сум хорооны нийгмийн ажилтнууд нь ийм гэр бүлд үйлчилгээ үзүүлэхэд соёлын ялгаа, ижилсэл зэрэг ойлголтуудын талаар бэлтгэгдсэн байх ёстой.

Угсаатны нийгмийн ажил нь сүүлийн хагас зуун жилд үүсэж, сүүлийн хориод жилд хөгжих хандлагатай байгаа боловч судалгааны үндсэн чиг хандлага нь дийлэнхдээ ноёрхогч соёлын үүднээс хийгдэж байгаа тухай барууны судлаачид тэмдэглэж байна. Эрдэмтэд Шведийн нийгмийн угсаатны нийгмийн ажлын хөгжлийг судлаад "Багш нарын сургалтын арга зүй, онолын хөгжил шаардлагатай сургалтын гарын авлага материал муу байгаа нь оюутнуудад "супер- олон талт байдал"-ын төвөгтэй нөхцөл байдалд ажиллаж чаддаг ур чадварыг эмшсэн боловсролыг олгоход сорилт тулгарч байгаа дурдсан.²

¹ Bongki Woo, Victor Figuereo, Robert Rosales, Kaipeng Wang, Kareemah Sabur (2018) Where is race and ethnicity in Social work? A Content Analysis. Social work research, Volume 42, Lssue 3, 180-186

² Lill, Linda, Jacobson, Pettersson, (2019 Vol. 38), Teaching ethnicity in social work education; teachers' experiences in Sweden. Social work education, 34-46

Монголын жишээн дээр глобал нийгмийн ажлын хөгжил ба Монголын "үндэсний цөөнх", "хэлний цөөнх", "соёлын цөөнх" бүлгийн үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийгмийн ажлын боловсрол хэрхэн нийцэж ирэв? Нийгмийн ажлын боловсрол олгож байгаа одоогийн тогтолцоо нь нийгмийн ажилтныг "угсаатантай холбоотой" мэдлэг (knowledge), хандлага, ур чадвар (skill) туршлагатай болгож төгсгөж чадаж байна уу гэсэн асуулт гарч ирж байна.

Нийтлэг байдлаар анхны хөтөлбөрүүд хүн ам зүй, нийгэм соёл, угсаатны зүй, түүхийн мэдлэг олгож байсан боловч дээр дурдсан олон янзын хэрэгцээ шаардлагад нийгмийн ажлын боловсролын хандлагаар буюу "хүний эрхийн", "олон талт байдлын" (diversity), "үл ялгаварлагдах байдал" (Non-discrimination) зэрэг хандлагууд чухал байна. Ийм учраас 2020 онд Нийгмийн ажлын боловсрол, сургалтын дэлхийн стандартыг шинэчлэн баталсан бөгөөд энэ стандартад үйлчлүүлэгчийн "олон талт байдал"-ыг харгалзан үзэх ёстой гэсэн үндсэн концепци илүү хүчтэй болсон байна.¹

Үндсэн хэсэг

Угсаатны нийгмийн ажил нь нэг талаасаа угсаатны судалгаа, нөгөө талаасаа нийгэм сэтгэл зүй, соёлын онол практикийн судалгаатай холбогддог учраас бусад салбар нийгмийн ажлаас илүүтэй нарийн төвөгтэй ойлголтуудыг хэрэглэдэг. Карол Кох ба Паул Эпгросс нар "Угсаатны ижилсэл" гэдгийг эртний, тодорхой газар нутагт нийтлэг гарал үүслээрээ холбогдсон, хамт төрсөн, эсвэл хүрч ирсэн бүлэг хүмүүсийн өөрсдийгөө "бид" гэж мэдэрдэг хамтын ухамсартай олон нийт (community) эсвэл дэд бүлэг хүмүүсийг хэлнэ. Мөн тухайн олон нийт нь угсаатан төвтэй үзэл бодолтой (ethnocentrism), бүлэгт өөрийгөө харьяалуулж байгаа гишүүд амьдрал, үйл ажиллагаандаа тухайн бүлгийн нийтлэг зан үйлийг баримталдаг, эв нэгдэлтэй (solidarity), ялгаатай бүлэг эсвэл олон нийтийн соёлын ижил биш шинж чанарыг мэдэрч байдаг. Карол Кох ба Паул Эпгросс нар угсаатны объектив ба субьектив талуудыг мөн дурдсан. Объектив талуудад нийтлэг хэл, шашин, уламжлалыг оруулдаг бол субьектив талыг хамтын мэдрэмж, харьяалсан байдал (belonging), эв нэгдэл (solidarity) зэрэг ойлголтуудыг оруулдаг.²

¹ О.Мөнхбат, Ш.Оюунханд, Т.Бүрэнжаргал "Нийгмийн ажил" сурах бичиг 405 тал


² О.Мөнхбат, Ш.Оюунханд, Т.Бүрэнжаргал "Нийгмийн ажил" сурах бичиг 407 тал

"Угсаатны линз" хэмээх ойлголт чухал юм. Учир нь дээр дурдсан "үндэсний цөөнх"-ийн түүх ба уламжлал, хэл ба соёл, шашин, үнэт зүйл ба шашин амьдрах хэв маяг нь нэг талаасаа тэдэнд "нийгмийн ба сэтгэл зүйн ижилсэл" нөгөө талдаа олонхоос ялгагдах ялгааг бий болгож байдаг. Тухайлбал манай орны хүн амын 90 гаруй хувь нь халх аялгаар ярьдаг бол 10 орчим хувь нь Монгол хэлний бусад аялга Буриад, ойрад аялгаар, Казах ба Тува нар Казах, Тувагаар ярьдаг байна. ¹ График 1-г харуулав.



График 1

Мөн Монголын Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн “Монгол улс дах шашны төлөв байдал” үндэсний хэмжээний суурь судалгааг 2020 онд хийсэн ба уг судалгаанаас хүн амын шашин шүтлэгийн байдлыг харвал нийт



¹ ҮСХ Монголын хүн ам зүйн судалгаа 2020 он

хүн амын 56% нь буддын шашин, 9% нь бөөгийн шашин, 7% христийн шашин, 6% нь исламын шашин, 2% шашны шинэ төрлийн урсгал, 20 хувь нь шашин шүтдэггүй гэсэн судалгаа гарчээ. График 2-г харуулав.

График 2

Угсаатын линзтэй холбоотой нийгмийн ажилд "линз модель" гэдэг ойлголт нь "Олон талт байдал" (diversity) гэдэг нь хүний эрх, эрхэм байдал (dignity) зөвшөөрөх нь өөрөө "үл ялгаварлагдах байдал"-тай (non-discrimination) шууд холбоотой. 1980 оны АНУ-ын Нийгмийн ажилтнуудын үндэсний холбооны (National Association of Social Workers) ёс зүйн кодоод "хувь хүний ялгаатай эрх" (right of individuals), олон талт байдал (diversity) гэдэг утгаараа туссан байдаг.

Жишээ нь хорих ял эдэлж буй казах хоригдол хорих ангийн нийгмийн ажилтан хэрхэн үйлчилгээг үзүүлэх, тухайн иргэний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлэхээс эхэлнэ. Уг бүлэг нь өөрсдийн ялгаатай байдал, цөөнх гэдгийгээ мэдрэх мэдрэмж, болгоомжлол, шашны ялгаатай байдал зэргийг нийгмийн ажилтан сайтар мэддэг байх ёстой.

"Угсаатан ба экологийн хандлага: Нийгмийн ажлын практикт экологийн хандлага нь туйлын чухал юм. Үйлчлүүлэгч гадаад орчны буюу сошиал системийн нөлөө, харилцан үйлдэлд оршин байдаг. Үүнтэй холбоотой "хабитат" гэсэн ойлголт гарч ирнэ. Ер нь ямар ч хүн өөрийн амьдарч байгаа газар, дэмжлэгийн систем тогтож хийж заншсан үйлдэл, зуршлууд байдаг. Эдгээр зуршлууд нь гадаад орчны шууд нөлөөн дээр бүрэлдэж бий болдог. Өдгөө Монгол нь хэдийгээр нэг угсаатан голлосон орон боловч барагцаагаар хүн амын 4 хувийг нь казах цөөнх, 1 хувь хүрэхгүй хэсэг нь тува цөөнх эзэлдэг. Эдгээр бүлэг нь хэл, соёл, шашин, амьдралын хэв маяг, түүхэн гарал үүсэл зэрэг бүх шалгуураар "үндэсний цөөнх"-ийн шалгуурт бүрэн нийцнэ. Казахуудын хувьд Баян-Өлгий аймагт голлон төвлөрч суудаг боловч Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Ховд зэрэг аймгуудад бий. Монголын хүн амын үндэстэн, ястны судалгааг 1956-2020 оны тоон үзүүлэлтээр график 3-т үзүүлэв.




График 3

Хорих байгууллагын нийгмийн ажлын практик ба угсаатан

Хорих байгууллагын нийгмийн ажилтан хоригдолд үйлчилгээ үзүүлэх бүхий л үе шатанд тухайн хоригдлын угсаатны онцлог, хэрэгцээ, ялгаатай байдлыг харгалзан үзэх ёстой. "Үйлчлүүлэгч-систем" буюу хоригдол ба нийгмийн ажилтан хоёр хоёул тусдаа систем юм.

Нийгмийн ажилтан нь үйлчилгээ үзүүлэх бүхий л явцад хоёр систем уулзана, хоригдол үйлчилгээ авахдаа өөрийн гэр бүл, харьяалагддаг бүлэг, хүйс, үнэт зүйл, соёлын ялгаагаа авчирна. Мөн тэдэнд өөрийнх нь угсаатны тогтсон сул болон давуу талуудаа үнэлсэн үнэлгээтэй байдаг.

Нийгмийн ажилтан бол өөрийн төлөөлж байгаа байгууллага, гишүүнчлэл, мөн хүйсийн ялгаа, мэргэжлийн үнэт зүйл ба өөрийн угсаатны ижилслийг авчирна. Үйлчилгээг үзүүлэх процесс нь ийм хоёр системийн хоорондын харилцан үйлчлэл болдог. Үйлчлүүлэгчийн /хоригдлын/ нууц нь тэдний угсаатны ижилсэл, харьяалагдаж байгаа сүлжээ, бүлэг, эргэн тойрон, гэр бүл, үнэт зүйл, соёлын хэм хэмжээтэй шууд холбогдоно. Тухайлбал тэд багаасаа "бидний нууц", "тэд мэдэх ёсгүй", "олон нийтэд ил болох ёсгүй", "угсаатны хувьд ичмээр" гэх мэт ойлголтыг суралцсан байдаг.

Угсаатны "олон нийт" бүр бусад угсаатантай харилцах, хүлээлт, туршлага бий болсон байдаг, үүнийг зохицуулж байдаг зохицуулалтууд байдаг чухам ийм зохицуулалт нь үйлчлүүлэгчийг "этник линз" буюу угсаатны нүдээр харахыг хэлнэ "Нийцтэй болох". Нийгмийн ажилтан ба хоригдолд үйлчилгээ үзүүлэх үйл явц нь дүрүүдээ (role) солилцох явц гэж үзэж болно, тэгэхээр нийгмийн ажилтан хоригдол хоёрын бие биеэсээ хүлээх "хүлээлт" (expectation) "нийцтэй байх" (matching clients and workers) нь тун чухал юм. Тухайн угсаатны ялгаатай хоригдолтой ажиллахад "хэлний" асуудал, "орчуулагч" буюу гуравдагч талтай холбоотой бүтэн багц сэдвүүд үүсдэг. "Дуугай байх", "нөгөө талын соёлын ялгаатай байдлыг ойлгосон мэт дүрд тоглох" зэрэг бэрхшээлүүд гардаг. Гэхдээ угсаатны ялгаатай байдал нь дангаараа биш хүйсийн, насны, нийгмийн, амьдралын туршлага, өвчтэй эсэх зэрэгтэй давхар, хавсарч, нийлж, цугтаа илэрдэг гэдгийг нийгмийн ажилтан санаж байх хэрэгтэй. Тиймээс "нийцтэй болох" гэдэг нь угсаатан мэдрэмжтэй хандлагын хамгийн чухал ойлголт бөгөөд үйлчлүүлэгч /хоригдол/ ба нийгмийн ажилтан хоёрын дүрийн хүлээлтийн зөрүүг багасгах нь мэргэжлийн нарийн үйл ажиллагаа юм.

Хорих байгууллагын нийгмийн ажилтан үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой дараагийн нэг чухал ойлголт бол "мэдрэмж ба тогтсон үзэл" (feeling and perceptions) юм. Хоригдол бүр өөрийн гэсэн тогтсон ойлголтыг бий болгосон байдаг. Тиймээс тэдний мэдрэмж ба тогтсон үзлийг нийгмийн ажилтан ойлгож улмаар итгэлцлийг бий болгох нь төвөгтэй гэхдээ чухал үйл явц юм. Өөрөөр хэлбэл хоригдол үйлчилгээ авч байхдаа "зөв газраа", "зөв хүнтэй" уулзаж байна гэж мэдрэх ёстой.

Нийгмийн ажилтны хувьд хоригдлын "угсаатны онцлогтой асуудал"-ыг ойлгож үр дүнтэй интервенц хийх шаардлагатай болно.

Гэхдээ хоригдлын угсаатны онцлогтой асуудал нь дангаараа бус ихэнх тохиолдолд "ялгаварлан гадуурхагдсан", "хэлний бэрхшээл", "шашин шүтэх эрх" гэх мэт бусад хүчин зүйлстэй хамтдаа илэрдэг. Тиймээс хоригдлын тулгамдаж байгаа асуудлыг оношлоход "угсаатны" онцлогийн илрэх нөлөө, харилцан хамаарал зэргийг нарийвчлан авч үзэхгүй бол үйлчилгээг үр өгөөжтэй өгөхөд саад болох болно.

"Угсаатны тэмдэг" (ethnic marker) гэдэг ойлголт нь угсаатны нийгмийн ажилд чухал байр суурийг эзэлдэг. Энэ нь угсаатан бүр өөрийн гэсэн онцлог шашин, үнэт зүйл, уламжлал, түүхээр илэрдэг. Тухайлбал Монголын цөөнх болсон казахуудын хувьд шашны хувьд муслим, гэр төвтэй үнэт зүйлтэй, өөрийн гэсэн түүх уламжлал бахархалтай угсаатан юм. Чухамдаа үүнийг ойлгохгүйгээр казах хоригдолд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ нь тэдэнд "итгэл" төрүүлж үр дүнтэй болж чадахгүй гэдэг нь эргэлзээгүй.

"Угсаатны харилцаа" (ethnic relation). Угсаатнуудын өөр хоорондын харилцааны өмнөх түүхийн бодит болон зохиомол миф нь тэдний харилцаанд шууд нөлөөлж байдаг. Нийгмийн ажилтан угсаатнуудын өөр хоорондын харилцааны түүхийг мэдэж байх шаардлагатай болдог. Хоригдлын асуудлыг тодорхойлохоос эхлээд оношлох цаашилбал үйлчилгээг эхлэхээс дуусгах хүртэл үйл явц нь өөрөө үүнийг шаардана. Монголын угсаатнуудын хувьд ийм өвөрмөц харилцаа нь тэдний өнгөрсөн цаг хугацаанд бүтээсэн түүх болон одоогийн тулгамдаад байгаа асуудлуудтай нягт холбоотой байдаг.

Карол Кох ба Паул Эпгросс нарын судлаачид дараах зөвлөгөөг нийгмийн ажилтнуудад өгсөн байдаг.¹ Үүнд:

1. Үйлчлүүлэгчийн угсаатны бүлгийн олон талт байдал, соёлын уламжлал, тэдний туршлага, урамшуулж байдаг зүйлийн талаар нийгмийн ажилтан тодорхой хэмжээний мэдлэгтэй, мөн мэдрэмжтэй (sensitive) байх нь чухал.

2. Угсаатны бүлэг бүр дотроо нэг төрөл биш төрөл бүрийн дэд бүлгүүдийг үүсгэж байдаг гэдгийг санах хэрэгтэй.

3. Үйлчлүүлэгчийн "угсаатны ижилсэл" (identity) бол нийгмийн ажилтны үнэлгээнд (assessment) маш чухал зүйл гэдгийг тооцох нь чухал. "Угсаатны линз" (lenses) гэсэн ойлголт нь үйлчлүүлэгчийн байр суурийг ойлгоход тусална.

5. Угсаатны бүлгийн үйлчлүүлэгчидтэй харьцахдаа угсаатны ялгаатай байдлыг харуулах "хил хязгаар" (boundaries), түүний нөлөөг тооцож сурах нь чухал.

¹ О.Мөнхбат, Ш.Оюунханд, Т.Бүрэнжаргал "Нийгмийн ажил" сурах бичиг 415 тал

6. Угсаатны бүлгийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг, зан заншил (customs), уламжлалт зан үйлийн (behavior) талаарх эерэг дүрийн (positive role) талаар нийгмийн ажилтан мэдлэгтэй байх ёстой.

7. Угсаатны ялгаа, түүнээс үүдэн бий болж байгаа дүрийг (role) нэг бол хэтрүүлэн эсвэл дутуу үнэлж болохгүй.

8. Үйлчлүүлэгчийн хэрэгцээг (need) тодорхойлоход угсаатны ялгаатай байдал нь үйлчлүүлэгчийн мэдрэмж, тогтсон ойлголтод (perception) гол нөлөө үзүүлдэг хүчин зүйл учраас нийгмийн ажилтан үүнийг тухайн бүлгийн тусгай онцлог хэрэгцээг хүлээн зөвшөөрөх нь чухал гэдгийг ойлгох ёстой.

9. Үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгчийн ойрын гэр бүл, орон нутгийн олон нийтийн лидерүүд, гэх мэт тухайн нийгэмлэг, хүрээндээ нэр хүндтэй олон янзын хүмүүсээс туслалцаа авах нь нийгмийн ажилтны үйлчилгээг чанартай үзүүлэхэд тусалдаг.¹

ДҮГНЭЛТ

Дэлхий дахины хэмжээнд даяарчлагдах үйл явц эрчимжихэд угсаатны зүй, хүн судлалын ухааны сэдэв улам нарийсаж, дүгнэлттэй хандах, ажиглалтын аргыг хэрэглэж ард түмний амьдрал ахуй, соёлын гүнд орж аливаа ёс заншил, зан үйлийн үүсэл, хувьслыг олж тодотгох таатай нөхцөл бүрдэж судалгааны чиг баримжаа нээгдсэн гэж үзэж болно. Угсаатны нийгмийн ажил нь АНУ-д 1950-иад оноос, Англи, Канад зэрэг орнуудад дараахнаас нь, Стандинавын орнуудад нэлээд сүүлд эрчимтэй хөгжиж эхэлсэн.

Энэхүү салбар шинжлэх ухаан нь тухайн ард түмний амьдрах орчин, мэдлэг сэтгэхүйд суурилан нийгэм, соёлын олон асуудлыг тал бүрээс нь авч үзэж нэгэн бүхэллэг зүйлийг шинжлэх ухаануудын заагт шийдэж өнгөрсөн, одоо, ирээдүйг харах боломжийг бүрдүүлдэг билээ. Өөрөөр хэлбэл барууны нийгмийн ажлын боловсролын хүчтэй нөлөөг тухайн орон нутгийн өөрийн онцлогт “нутагшуулж” зүй зохистойгоор хөгжүүлнэ гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл Монгол нийгмийн ажлын агуулгыг бид судалгаа, үйлчилгээ, сургалтад нэвтрүүлэх ёстой гэсэн үг юм.

Монголд байгаа казах иргэд бол олон улсын хуулийн статусаараа ч түүх соёл, хэл ёс заншил шашнаараа ч гэсэн Монгол дахь "Үндэсний цөөнх" гэдэг ангилалд бүрэн орох ба нийгмийн ажилтнууд нь тухайн нийгмийн “үндэсний цөөнх” үйлчлүүлэгч, тэдний олон нийтийн үнэт зүйл, соёл, шашин, зан үйл, амьдрах хэв хаягийг ойлгож нийгмийн ажлын үйлчилгээндээ тусгах ёстой болдог.

¹ Carole B. Cox, Paul H. Ephross (2009), Ethnicity in American Society.

Хорих байгууллагын нийгмийн ажилтан хоригдлын угсаатны ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, мэдрэмжтэй хандах чинь чухал юм. Энэ нь хоригдол ба нийгмийн ажилтан хоёр нь нэг угсаатан биш тохиолдолд хэрхэн харилцан бие биеийнхээ ялгаа, онцлогийг хүлээн зөвшөөрч итгэлцэл бий болгож байгаагаас хамаарч нийгмийн ажлын үйлчилгээний чанар шууд хамаарна.

САНАЛ

Нийгмийн ажлын салбар бүрд тухайн салбарын үйлчлүүлэгчийн угсаатны ялгаатай байдлыг хүндэтгэн мэргэжлийн үйлчилгээг хүргэхэд анхаарч, мэдрэмжтэй байх арга зүйг нийгмийн ажилтан бэлтгэж буй их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулгад оруулах, энэ төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх,

Нийгмийн бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, нийгмийн ажлын үйлчилгээг гардан хүргэгч нийгмийн ажилтан, нийгмийн ажилтны орон тоон дээр ажиллаж байгаа мэргэжилтнүүд "угсаатны линз" хэмээх ойлголтын талаарх мэдлэгээ нэмэгдүүлж, хандлагаа төлөвшүүлж, туршлагаа нэмэгдүүлэх шаардлагатай,